

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2023/159/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: У.Ербол
Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

АОУС Аудитын Олон Улсын стандарт

ОБЕГ Онцгой байдлын ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ДЭД
ХУРАНДАА З.АЗАТ ТАНАА

2023.02.09 № 32
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Онгой байдлын ерөнхий газраас 357.4 сая төгрөгийн бараа материал, 195.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авч, байгууллагын эзэмшил газрын эзэмшил эрхийн бичгийг 320.0 сая төгрөгөөр үнэлж шинээр бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,006,856,261.89</u>	<u>1,222,662,465.89</u>
34	УРЬДЧИЛГАА	26,000,000.00	40,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	26,000,000.00	40,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	980,856,261.89	1,182,662,465.89
351	Түүхий эд материал	687,489,422.64	874,200,927.64
35110	Тусгай зориулалттай материал	625,053,233.24	812,060,058.24
35130	Эм боох материал	62,436,189.40	62,140,869.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	159,158,322.25	173,017,282.25
354	Хангамжийн материал	133,358,517.00	134,594,256.00
35410	Бичиг хэргийн материал	1,550,050.00	4,391,335.00
35420	Аж ахуйн материал	63,229,220.00	62,979,984.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,971,563.00	14,719,063.00
35440	Түлш, шатах тослох материал	2,655,320.00	6,078,800.00
35450	Барилгын засварын материал	-	1,686,750.00
35460	Хүнсний материал	3,122,340.00	-
35470	Бусад хангамжийн материал	55,830,024.00	44,738,324.00
35600	Мал амьтад	850,000.00	850,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,608,232,886.54</u>	<u>6,242,921,732.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,608,232,886.54	6,242,921,732.01
392	Биет хөрөнгө	6,141,153,886.70	5,455,892,732.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,818,741,201.03	4,839,188,201.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,530,269,520.85)	(1,945,827,237.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,853,532,882.00	4,022,832,882.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,048,564,002.84)	(1,483,084,369.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	984,869,814.80	984,237,014.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(965,976,626.84)	(970,390,893.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,587,100.73	26,976,100.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,691,961.61)	(18,038,965.49)
39214	Бусад үндсэн хөрөнгө	108,951,130.20	78,769,130.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(93,026,129.92)	(78,769,130.20)
393	Биет бус хөрөнгө	467,078,999.84	787,029,000.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.16)	(250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	467,029,000.00	787,029,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>7,615,089,148.43</u>	<u>7,465,584,197.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,615,089,148.43</u>	<u>7,465,584,197.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,615,089,148.43	7,465,584,197.90

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	794,950,269.92	794,950,269.92
51101	Өмч: - төрийн	794,950,269.92	794,950,269.92
512	Хуримтлагдсан үр дүн	2,958,451,829.34	2,808,946,878.81
51210	Өмнөх үеийн үр дүн	2,323,820,120.65	2,958,451,829.34
51220	Тайлант үеийн үр дүн	634,631,708.69	(149,504,950.53)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,861,687,049.17	3,861,687,049.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,615,089,148.43</u>	<u>7,465,584,197.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,429,710,540.48	2,755,347,799.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,386,686,461.48	357,456,162.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,386,686,461.48	357,456,162.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,386,686,461.48	357,456,162.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,386,686,461.48	357,456,162.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,043,024,079.00	2,397,891,637.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,829,934,800.00	2,303,513,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,829,934,800.00	1,783,228,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	520,285,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	213,089,279.00	94,378,137.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,495,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,320,785.00	54,493,887.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,554,950.00	33,146,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,718,544.00	6,737,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,795,078,831.79	2,900,609,479.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,795,078,831.79	2,900,609,479.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,768,893,499.79	2,896,981,183.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,446,285,465.00	1,507,691,890.00
210101	Үндсэн цалин	834,230,865.00	890,356,290.00
210102	Нэмэгдэл	571,761,600.00	579,220,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,293,000.00	38,115,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,566,303.00	52,292,200.00
210201	Тэтгэврийн даатгал	26,939,500.00	27,522,900.00

210202	Тэтгэмжийн даатгал	15,935,703.00	22,872,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,352,700.00	1,407,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	338,400.00	489,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,074,000.00	84,202,300.00
210301	Гэрэл, цахилгаан	11,006,300.00	8,963,013.00
210302	Түлш, халаалт	68,222,400.00	72,804,757.00
210303	Цэвэр, бохир ус	4,845,300.00	2,434,530.00
2104	Хангамж, бараа материалын зардал	112,706,245.00	90,317,616.00
210401	Бичиг хэрэг	3,522,970.00	4,653,710.00
210402	Тээвэр, шатахуун	81,725,886.00	79,898,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,922,681.00	2,217,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,358,500.00	1,430,000.00
210408	Бараа материал акталсны зардал	23,176,208.00	2,117,936.00
2105	Нормативт зардал	260,797,458.95	155,411,457.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,234,854.70	863,320.00
210502	Хоол, хүнс	83,971,190.00	66,593,460.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	148,591,414.25	87,954,677.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,204,548.00	25,594,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,261,200.00	261,050.00
210604	Урсгал засвар	133,943,348.00	25,333,700.00
2107	Томилолт, зочны зардал	94,184,700.00	29,455,800.00
210702	Дотоод албан томилолт	94,184,700.00	29,455,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,453,700.00	11,222,829.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,745,400.00	738,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,932,400.00	3,932,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	683,300.00	1,117,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	638,000.00	612,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,325,600.00	2,269,715.00
210807	Газрын төлбөр	3,129,000.00	2,553,014.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	574,621,079.84	940,792,341.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,240,950.00	47,983,397.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,408,980.00	4,283,790.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	532,971,149.84	888,525,154.53

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,185,332.00	3,628,296.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,767,100.00	2,460,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,767,100.00	2,460,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,418,232.00	1,168,296.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,418,232.00	1,168,296.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	634,631,708.69	(145,261,680.53)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	6,741,730.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	6,741,730.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	10,985,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	10,985,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(4,243,270.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	634,631,708.69	(149,504,950.53)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,043,024,079.00	1,877,606,637.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,043,024,079.00	1,877,606,637.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,829,934,800.00	1,783,228,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,829,934,800.00	1,783,228,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	213,089,279.00	94,378,137.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,495,000.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,320,785.00	54,493,887.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,554,950.00	33,146,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,718,544.00	6,737,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,043,024,079.00	1,874,677,637.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,043,024,079.00	1,874,677,637.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,016,838,747.00	1,869,005,941.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,446,285,465.00	1,507,691,890.00
210101	Үндсэн цалин	834,230,865.00	890,356,290.00
210102	Нэмэгдэл	571,761,600.00	579,220,600.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,293,000.00	38,115,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,566,303.00	52,292,200.00
210201	Тэтгэврийн даатгал	26,939,500.00	27,522,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,935,703.00	22,872,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,352,700.00	1,407,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	338,400.00	489,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,347,000.00	86,706,800.00
210301	Гэрэл, цахилгаан	11,006,300.00	9,592,600.00
210302	Түлш, халаалт	69,495,400.00	74,495,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,845,300.00	2,619,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,781,901.00	13,620,650.00
210401	Бичиг хэрэг	2,998,100.00	2,407,700.00
210402	Тээвэр, шатахуун	49,348,720.00	7,555,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,935,081.00	2,227,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,430,000.00
2105	Нормативт зардал	77,420,780.00	61,794,910.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	595,800.00	568,000.00
210502	Хоол, хүнс	76,824,980.00	61,226,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,730,200.00	26,996,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,363,100.00	5,021,300.00
210604	Урсгал засвар	98,367,100.00	21,975,000.00
2107	Томилолт, зочны зардал	94,184,700.00	29,455,800.00
210702	Дотоод албан томилолт	94,184,700.00	29,455,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,693,700.00	26,560,714.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,745,400.00	15,580,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,932,400.00	3,932,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	683,300.00	1,117,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	638,000.00	612,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,565,600.00	2,765,600.00
210807	Газрын төлбөр	3,129,000.00	2,553,014.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,828,698.00	63,886,677.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,182,398.00	57,612,477.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,646,300.00	6,274,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,185,332.00	5,671,696.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	4,767,100.00	4,503,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,767,100.00	4,503,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,418,232.00	1,168,296.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,418,232.00	1,168,296.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	2,929,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,929,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,929,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,929,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2,929,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(2,929,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,323,578,920.65	0.00	6,980,457,439.74
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			634,631,708.69		634,631,708.69
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,958,210,629.34	0.00	7,615,089,148.43
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,958,210,629.34	0.00	7,615,089,148.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,958,451,829.34	0.00	7,615,089,148.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-149,504,950.53		-149,504,950.53
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,808,946,878.81	0.00	7,465,584,197.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,783,228,500.00	1,783,172,204.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,783,228,500.00	1,783,172,204.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,778,725,100.00	1,778,668,804.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,507,700,100.00	1,507,691,890.00
210101	Үндсэн цалин	890,364,500.00	890,356,290.00
210102	Нэмэгдэл	579,220,600.00	579,220,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,115,000.00	38,115,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,292,200.00	52,292,200.00
210201	Тэтгэврийн даатгал	27,522,900.00	27,522,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,872,100.00	22,872,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,407,600.00	1,407,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	489,600.00	489,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,323,800.00	86,323,800.00
210301	Гэрэл, цахилгаан	9,592,600.00	9,592,600.00
210302	Түлш, халаалт	74,112,000.00	74,112,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,619,200.00	2,619,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,064,900.00	8,064,900.00
210401	Бичиг хэрэг	2,407,700.00	2,407,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,227,200.00	2,227,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,430,000.00	1,430,000.00
2105	Нормативт зардал	61,283,500.00	61,283,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	568,000.00	568,000.00
210502	Хоол, хүнс	60,715,500.00	60,715,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,996,300.00	26,996,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,021,300.00	5,021,300.00
210604	Урсгал засвар	21,975,000.00	21,975,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,415,400.00	1,381,300.00
210702	Дотоод албан томилолт	1,415,400.00	1,381,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,374,700.00	28,360,714.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,580,200.00	15,580,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,932,400.00	3,932,400.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,117,100.00	1,117,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	612,400.00	612,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,565,600.00	4,565,600.00
210807	Газрын төлбөр	2,567,000.00	2,553,014.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,274,200.00	6,274,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,274,200.00	6,274,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,503,400.00	4,503,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,503,400.00	4,503,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,503,400.00	4,503,400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,783,228,500.00	1,783,172,204.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,783,228,500.00	1,783,172,204.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,783,228,500.00	1,783,172,204.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	112	112
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	90	90
620003	Үйлчлэх ажилтан	17	17
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	112	112
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	91	91
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	17
650010	Гэрээт ажилтан	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	204,089,279.00	93,266,137.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	204,089,279.00	93,266,137.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	204,089,279.00	93,266,137.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,381,000.00	383,000.00
210302	Түлш, халаалт	1,381,000.00	383,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,296,901.00	5,555,750.00
210401	Бичиг хэрэг	472,500.00	-
210402	Тээвэр, шатахуун	14,225,620.00	5,555,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	598,781.00	-
2105	Нормативт зардал	21,528,980.00	511,410.00
210502	Хоол, хүнс	21,528,980.00	511,410.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	92,700,000.00	28,074,500.00
210702	Дотоод албан томилолт	92,700,000.00	28,074,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,182,398.00	58,741,477.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,182,398.00	58,741,477.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		- 1,112,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,112,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	213,089,279.00	94,378,137.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	213,089,279.00	94,378,137.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,495,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67,320,785.00	54,493,887.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97,554,950.00	33,146,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,718,544.00	6,737,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын зорилго нь аймгийн хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх замаар иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

- Офицерын манлайлал, бие бүрэлдэхүүний сургалт, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх
- Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг сайжруулж, эрсдэлийг бууруулах хамтын ажиллагааг бэхжүүлэх

Үйл ажиллагааны чиглэл: Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Аймгийн Онцгой байдлын газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай хууль Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын

зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд ОБЕГ-ын Хяналт, шалгалтын газраас тус газрын үйл ажиллагаанд дотоод аудитын чиглэлээр хяналт шалгалт хийгдэж, хяналт шалгалтаар 3 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ОБЕГ-ын даргын 2016 оны А/293 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг шинэчлэн батлах тухай журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Онцгой байдлын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 149.5 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0

Урьдчилгаа	26,000.0	40,000.0	14,000.0
Бараа материал	980,856,3	1,182,662,5	201,806,2
Үндсэн хөрөнгө	6,608,232,8	6,242,921,7	(149,504,9)
Нийт хөрөнгө	7,615,089,2	7,465,584,2	(149,504,9)
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,615,089,2	7,465,584,2	(149,504,9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,615,089,2	7,465,584,2	(149,504,9)

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд өөрчлөлт гараагүй, өр төлбөргүй ажилласан байна.

Урьдчилгаа дансны авлага 40.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Цамбагарав Өгөөж ХХК-с 54 м2 талбай бүхий 2 өрөө орон сууцыг 54.0 сая төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ байгуулж орон сууцны /албаны орон сууц / урьдчилгаанд 40.0 сая төгрөгийг төлж урьдчилж гарсан бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 201.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ОБЕГ-аас тусгай зориулалтын материал, бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 149.5 сая төгрөгөөр буурсан нь ОБЕГ-аас 119.8 сая төгрөгийн Ланд-78 авто машин, ОБЕГ-ын дэргэдэх 115 дугаар ангиас 6.0 сая төгрөгийн Соната-7, 185 дугаар ангиас 70.0 сая төгрөгийн Фургон авто машин нийлүүлсэн, ТӨБЗГ-ын 2022 оны А-1/2604 тоот албан бичгээр өөрийн эзэмшилд байгаа газрын эрхийн бичгийг 320.0 сая төгрөгөөр үнэлүүлж бүртгэлд авсан, тайлант онд 45.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсан болон тухайн оны элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 149.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2391.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 144.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 4.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 26.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 46.9 сая төгрөгөөр, нормативт зардал 3.9 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 201.7 сая төгрөгөөр, томилолт, зочны зардал 7.1 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 13.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 79.4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 11.1 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсвийг 29.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1753.7 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1783.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, тээвэр шатахууны зардалд 68.7 сая төгрөгийг талоноор болон картаар санхүүжүүлж, 0.05 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1783.2 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1778.7	1778.7		100%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4.5	4.5		100%
	Дүн	1783.2	1783.2		100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ОБЕГ-аас гамшиг ослын томилолт болон ахмадын сангийн санхүүжилтэд 33.1 сая төгрөгийн, аймгийн Засаг даргын дэмжлэгээс 61.3 сая төгрөгийн санхүүжилт авч, 93.3 сая төгрөгийг гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гамшиг ослын томилолт, тусгаарлах байрны төлбөр, тээвэрлэлтийн зардалд тус тус зарцуулж 1.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Онцгой байдлын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 19/21 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2795.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 41.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ОБЕГ-аас байр ашиглалттай холбоотой зардлыг 6.3 сая төгрөгөөр бууруулж 86.3 сая төгрөгөөр баталсан ба тайлант онд батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаагаа явуулж, жилийн эцэст өр төлбөргүй ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнээс 1836.3 сая төгрөгийн 15 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээнээс 87.3 сая төгрөгийн 11 мэдээллийг оруулахаас, мэдээлбэл зохих бүх мэдээллийг цаг тухайд нь бүрэн мэдээлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудитын хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар бараа материалын дансанд орлогод авсан 3.9 сая төгрөгийн компьютер, принтерийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэж, зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул, гүйцэтгэлийн аудитаар цалингийн зардал болон бусад зардлуудыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

Байхгүй.

5.3 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

